



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайншанд сумын Зүүнбаян Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2024/182/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2024 он | Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Ахлах аудитор: Г.Энхтөр Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Цахим хаяг: ij17.audit@gmail.com |
|---|---|

1.Аудитын санал дүгнэлт



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гуламж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024 02 23 № 1-6/140

танай _____-ны № _____-т

САЙНШАНД СУМЫН ЗҮҮНБАЯН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ О.ЦЭЦЭГМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын Зүүнбаян Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын Зүүнбаян Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь Шилэн дансны сайтад хуулийн 6.4.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл болох 685.5 сая төгрөгийн 105 мэдээлэл байршуулахаас 69.7 сая төгрөгийн 5 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

АДБООС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

010020009

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------|---|----------------|-----------------|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 66,495,799.38 | 119,658,010.00 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 10,246,422.42 | 63,652,081.64 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 10,246,422.42 | 63,652,081.64 |
| 3121 | Төгрөг | 10,246,422.42 | 63,652,081.64 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 10,246,422.42 | 63,652,081.64 |
| 33 | АВЛАГА | 585,829.00 | 585,829.00 |
| 335 | Бусад авлага | 585,829.00 | 585,829.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 585,829.00 | 585,829.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 55,663,547.96 | 55,420,099.36 |
| 351 | Түүхий эд материал | 4,578,100.00 | 4,578,100.00 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | 4,578,100.00 | 4,578,100.00 |
| 354 | Хангамжийн материал | 51,085,447.96 | 50,841,999.36 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 3,018,835.60 | 0.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 33,995,809.29 | 40,926,409.29 |
| 3544 | Түлш, шатах тослох материал | 0.07 | 0.07 |
| 3546 | Хүнсний материал | 10,931,603.00 | 6,776,390.00 |
| 3547 | Бусад хангамжийн материал | 3,139,200.00 | 3,139,200.00 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 594,106,305.02 | 556,235,163.45 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 594,106,305.02 | 556,235,163.45 |
| 392 | Биет хөрөнгө | 540,946,638.14 | 503,507,246.49 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 592,502,235.00 | 592,502,235.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -84,924,087.35 | -108,624,176.75 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 66,563,285.00 | 66,563,285.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -51,996,100.94 | -56,970,217.77 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 106,267,208.26 | 106,267,208.26 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -88,142,360.79 | -96,907,546.21 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 19,315,000.00 | 19,315,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -19,300,000.00 | -19,300,000.00 |
| 39217 | Ном | 661,458.96 | 661,458.96 |
| 393 | Биет бус хөрөнгө | 53,159,666.88 | 52,727,916.96 |
| 39301 | Програм хангамж | 1,727,000.00 | 1,727,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,151,333.12 | -1,583,083.04 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 52,584,000.00 | 52,584,000.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 660,602,104.40 | 675,893,173.45 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 459,734.96 | 2,338,000.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 459,734.96 | 2,338,000.00 |
| 413 | Өглөг | 459,734.96 | 2,338,000.00 |
| 4131 | Ажилчидтай холбогдсон өглөг | 459,734.96 | 0.00 |
| 4132 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 0.00 | 2,260,000.00 |
| 4136 | Бусад өглөг | 0.00 | 78,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 0.00 | 78,000.00 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 660,142,369.44 | 673,555,173.45 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 660,142,369.44 | 673,555,173.45 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 480,946,136.05 | 480,946,136.05 |
| 51101 | Өмч: - төрийн | 480,946,136.05 | 480,946,136.05 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 179,196,233.39 | 192,609,037.40 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 179,196,233.39 | 179,196,233.39 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 13,412,804.01 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 660,602,104.40 | 675,893,173.45 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------|---|----------------|----------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 527,581,579.25 | 666,668,955.15 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 103,500.00 | 3,047,504.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 103,500.00 | 3,047,504.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 103,500.00 | 3,047,504.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 103,500.00 | 3,047,504.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 527,478,079.25 | 663,621,451.15 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 458,263,300.00 | 624,272,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 458,263,300.00 | 624,272,500.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 69,214,779.25 | 39,348,951.15 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 69,214,779.25 | 39,348,951.15 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 542,645,584.96 | 653,256,151.14 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 542,645,584.96 | 653,256,151.14 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 542,645,584.41 | 644,332,451.14 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 381,615,115.93 | 450,437,191.24 |
| 210101 | Үндсэн цалин | 297,635,232.43 | 332,505,786.25 |
| 210102 | Нэмэгдэл | 74,215,477.10 | 98,480,608.61 |
| 210104 | Урамшуулал | 9,764,406.40 | 19,450,796.38 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 44,855,196.94 | 55,567,708.58 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,096,996.94 | 36,088,708.58 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,870,500.00 | 4,870,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,220,400.00 | 4,001,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,406,100.00 | 868,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,261,200.00 | 9,739,300.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 35,175,602.70 | 38,948,951.15 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,301,099.70 | 9,777,552.15 |
| 210302 | Түлш, халаалт | 25,863,500.00 | 25,862,375.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,011,003.00 | 3,309,024.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,077,430.00 | 78,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,508,800.00 | 0.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 279,750.00 | 0.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 87,000.00 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 309,000.00 | 78,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 892,880.00 | 0.00 |
| 2105 | Нормативт зардал | 29,677,827.00 | 44,327,523.00 |
| 210502 | Хоол, хүнс | 29,677,827.00 | 44,327,523.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 243,500.00 | 814,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 243,500.00 | 814,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 908,000.00 | 875,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 908,000.00 | 875,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 47,092,911.84 | 53,284,077.17 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,773,420.00 | 13,876,535.60 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 541,100.00 | 1,536,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 41,778,391.84 | 37,871,141.57 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 0.55 | 8,923,700.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 0.00 | 8,923,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.00 | 8,923,700.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 0.55 | 0.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.55 | 0.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | -15,064,005.71 | 13,412,804.01 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | -15,064,005.71 | 13,412,804.01 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|--------|---|----------------|----------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 527,581,579.25 | 666,668,955.15 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 103,500.00 | 3,047,504.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 103,500.00 | 3,047,504.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 103,500.00 | 3,047,504.00 |
| 1E+06 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 103,500.00 | 3,047,504.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 527,478,079.25 | 663,621,451.15 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 458,263,300.00 | 624,272,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 458,263,300.00 | 624,272,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 69,214,779.25 | 39,348,951.15 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 69,214,779.25 | 39,348,951.15 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 517,335,156.83 | 613,263,295.93 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 517,335,156.83 | 613,263,295.93 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 517,335,156.28 | 604,339,595.93 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 379,957,919.46 | 450,896,926.20 |
| 210101 | Үндсэн цалин | 295,978,035.96 | 310,093,260.11 |
| 210102 | Нэмэгдэл | 74,215,477.10 | 121,352,869.71 |
| 210104 | Урамшуулал | 9,764,406.40 | 19,450,796.38 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 47,022,034.12 | 55,567,708.58 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,263,834.12 | 36,088,708.58 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,870,500.00 | 4,870,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,220,400.00 | 3,895,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 788,200.00 | 974,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,879,100.00 | 9,739,300.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 35,148,102.70 | 38,948,951.15 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,273,599.70 | 9,777,552.15 |
| 210302 | Түлш, халаалт | 25,863,500.00 | 25,862,375.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,011,003.00 | 3,309,024.00 |
| 2105 | Нормативт зардал | 40,504,000.00 | 38,741,810.00 |
| 210502 | Хоол, хүнс | 40,504,000.00 | 38,741,810.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 400,000.00 | 400,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 400,000.00 | 400,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 962,000.00 | 875,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 962,000.00 | 875,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,341,100.00 | 18,909,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,841,100.00 | 16,163,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,500,000.00 | 2,745,700.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 0.55 | 8,923,700.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 8,923,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 8,923,700.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 0.55 | |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.55 | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 10,246,422.42 | 53,405,659.22 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 10,246,422.42 | 53,405,659.22 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 10,246,422.42 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 10,246,422.42 | 63,652,081.64 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|-----|---------------------------------------|--------------------|-----------------------|----------------------|-------------------------|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 480,946,136.05 | - | 194,260,239.10 | 675,206,375.15 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | - | - | (15,064,005.71) | (15,064,005.71) |
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 480,946,136.05 | - | 179,196,233.39 | 660,142,369.44 |
| 17 | Тайлант үеийн үр дүн | - | - | 13,412,804.01 | 13,412,804.01 |
| 19 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 480,946,136.05 | - | 192,609,037.40 | 673,555,173.45 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---------|--|----------------|----------------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 683,047,100.00 | 613,263,295.93 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 683,047,100.00 | 613,263,295.93 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 674,123,400.00 | 604,339,595.93 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 491,609,200.00 | 450,896,926.20 |
| 210101 | Үндсэн цалин | 318,516,200.00 | 310,093,260.11 |
| 210102 | Нэмэгдэл | 150,704,800.00 | 121,352,869.71 |
| 210104 | Урамшуулал | 22,388,200.00 | 19,450,796.38 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 61,806,800.00 | 55,567,708.58 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,142,100.00 | 36,088,708.58 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,916,400.00 | 4,870,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,932,800.00 | 3,895,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 983,300.00 | 974,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,832,200.00 | 9,739,300.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 45,080,700.00 | 38,948,951.15 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,600,000.00 | 9,777,552.15 |
| 210302 | Түлш, халаалт | 27,643,900.00 | 25,862,375.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,836,800.00 | 3,309,024.00 |
| 2105 | Нормативт зардал | 55,073,800.00 | 38,741,810.00 |
| 210502 | Хоол, хүнс | 55,073,800.00 | 38,741,810.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 400,000.00 | 400,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 400,000.00 | 400,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 915,200.00 | 875,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 915,200.00 | 875,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,237,700.00 | 18,909,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,492,000.00 | 16,163,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,745,700.00 | 2,745,700.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 8,923,700.00 | 8,923,700.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 8,923,700.00 | 8,923,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,923,700.00 | 8,923,700.00 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 683,047,100.00 | 666,668,955.15 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 0.00 | 624,272,500.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 0.00 | 624,272,500.00 |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 45,480,700.00 | 39,348,951.15 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 45,480,700.00 | 39,348,951.15 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 0.00 | 3,047,504.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 3,047,504.00 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 10,246,422.42 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 10,246,422.42 | 63,652,081.64 |

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2 алдаа зөрчил илэрснээс, 2 зөвлөмж өгсөн.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|-------------|----------|---------------|----------|-----------------|----------|----------|----------|---|----------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хөрөнгийн тооллогын акт, үр дүнг баталгаажуулсан жагсаалтыг нягтлан бодогчид хүлээлгэн өгөөгүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| Тайлант онд үүссэн авлагыг барагдуулах | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| Дүн | 2 | - | - | - | - | - | 2 | - | - | - |

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан.

Шилэн дансанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв, хугацаанд нь мэдээлээгүй болон бусад холбогдох хууль, дүрэм журам зөрчсөн 69,680.9 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 2 зөвлөмж хүргүүлсэн.

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|-------------|-----------------|---------------|----------|-----------------|----------|----------|-----------------|--|--|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | | |
| Мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан | 1 | 69,680.9 | - | - | - | - | 1 | 69,680.9 | | |
| Дүн | 1 | 69,680.9 | - | - | - | - | 1 | 69,680.9 | | |
| Төрийн хэмнэлтийн хууль | | | | | | | | | | |
| Аж ахуйн материалын үлдэгдэл өмнөх оноос нэмэгдсэн | 1 | - | - | - | - | - | - | - | | |
| Дүн | 1 | - | - | - | - | - | 1 | - | | |
| Нийт дүн | 2 | 69,680.9 | - | - | - | - | 2 | 69,680.9 | | |